



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/327

Хэрлэн сум

**Дуудлага худалдаа зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 242 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулж дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч Байгаль орчны газрын дарга (Б.Амгаланбат)-д даалгасугай

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 06-ний өдрийн
А.1324 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Амгаланбат

Байгаль орчны газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

Б.Нандинбаатар

Байгаль орчны газрын мэргэжилтэн

Гишүүд:

Д.Билгээ

Орон нутгийн өмчийн газрын дарга

Б.Мөнхжаргал

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн ахлах
мэргэжилтэн

А.Ганболд

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйл, Амьтны тухай хуулийн 29¹.3 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулан явуулахдаа энэхүү удирдамжийг баримтална.

1.2.Аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах тусгай зөвшөөрөл олгох, дуудлага худалдааг зохион байгуулан явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, дуудлага худалдаа явуулах ажлын удирдамжийг боловсруулна.

1.3.Тус удирдамжийн 1.2-т заасан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар багтсан 5-7 гишүүнтэй байна.

1.4.Засгийн газрын тогтоолд заасан тусгай зориулалтын агнуурын зөвшөөрлийн дуудлага худалдааны эхлэх босго үнийн хэмжээг дуудлага худалдааны анхны үнийн санал гэж тооцно.

1.5.Дуудлага худалдаанд тухайн агнуурын бүс нутгийн амьтдыг Засгийн газрын тогтоолоор батлагдсан хуваарийн дагуу тухайн зүйл амьтныг нэг болон хэд хэдэн ширхэгээр, төрөл зүйлээр багцалж дуудлага худалдааг зохион байгуулж болно.

Хоёр. Дуудлага худалдаа зохион байгуулахад баримтлах зарчим

2.1. Дуудлага худалдааг зохион байгуулахад дараах зарчмыг баримтална.

2.1.1.Дуудлага худалдаанд оруулах агнуурын амьтныг Засгийн газрын тогтоолоор баталсан тооноос хэтрүүлэхгүй байх;

2.1.2. Нээлттэй, ил тод байх;

2.1.3. Тэгш, шударга оролцоог хангасан байх.

2.1.4. Холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөх

Гурав. Дуудлага худалдааны хэлбэр, дуудлага худалдаа явуулах дараалал

3.1.Дуудлага худалдааг цахимаар зүүм /zoom/ апплейкшн цаашид (программ гэх) ашиглан нээлттэй, ил тод зохион байгуулна.

3.2.Дуудлага худалдааг дараах дарааллын дагуу явуулна:

3.2.1.Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

3.2.2.Дуудлага худалдааг зарлан мэдээлэх;

3.2.3.Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх, дуусгавар болгох.

3.2.4.Дуудлага худалдааг явуулах;

3.2.5.Дуудлага худалдааны ялагчийг зарлах баталгаажуулах

3.2.6.Ан агнах, барих зөвшөөрлийн бичгийг бичиж олгох

Дөрөв. Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах

4.1.Тус удирдамжийн 1.3-д заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэнэ:

4.1.1. Дуудлага худалдааны тов, агнах, барих амьтны хуваарь, багц, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдааны зохион байгуулалт, хэлбэр, хугацаа, дэнчингийн хэмжээг тогтоосон шийдвэрийн төслийг бэлтгэсэн байна.

4.1.2. Хуульд заасан шаардлагад нийцсэн, төрийн байгууллагуудад ашиглагдаж туршигдсан, программ хангамж ашиглах туршилт хийж бэлэн болгоно. Аудио /видео хэлбэрээр үнийн санал өгөх, аудио/ видео бичлэг хийж хадгалах баталгаажуулах, зохион байгуулагчид болон бүх оролцогчид харилцан хяналт тавих боломж бүхий **zoom** буюу түүнтэй төстэй программ ашиглана.

Тав. Дуудлага худалдааны зарыг зарлан мэдээлэх

5.1. Дуудлага худалдааны зар (цаашид "зар" гэх)-ыг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар олон нийтэд мэдээлнэ:

5.1.1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон Байгаль орчны газрын цахим хуудсаар;

5.1.2. Дуудлага худалдаагаар агнах, барих амьтныг агнуулах, барьж буцаан тавиулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

5.2. Дуудлага худалдааны хэлбэр;

5.2.1. Дуудлага худалдаа зохион байгуулах цахим хуудасны мэдээлэл (дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамж бүхий), харилцах утасны дугаар;

5.2.2. Дуудлага худалдаанд оруулах агнуурын бүс нутгийн нэр, агнуулах, барьж буцаан тавиулах амьтны зүйлийн нэр, тоо толгой болон тухайн агнуурын бүс нутгийн нэр, агнуулах, барьж буцаан тавиулах амьтны зүйлийн нэр, тоог багцалсан мэдээллийг;

5.2.3. Дуудлага худалдааны босго үнэ;

5.2.4. Дэнчингийн хэмжээ, дэнчин тушаах дансны дугаар, дэнчин төлөх сүүлийн хугацаа;

5.2.5. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

5.2.6. Дуудлага худалдаа эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг;

5.2.7. Дуудлага худалдааны босго үнийг өсгөх интервалийн хэмжээг зард зайлшгүй тусгана.

Зургаа. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх

6.1. Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд хүсэлтээ энэ удирдамжийн хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв гаргаж khentiinature@gmail.com цахим шуудангийн хаягаар дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө илгээсэн байна.

6.2. Дуудлага худалдаанд оролцогч дуудлага худалдаанд оролцох хүсэлтдээ дараах материалыг хавсаргаж, цахимаар илгээнэ.

6.2.1. Хуулийн этгээдийн байгууллагыг төлөөлж оролцох тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын олгосон нотариатаар батлуулсан итгэмжлэл, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримт, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажилтны үнэмлэх;

6.2.2. Дэнчин төлсөн баримтын хуулбар;

6.2.3. Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсныг цахим дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ

6.3. Бүртгэлийг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө хаана;

6.4. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг дуудлага худалдаанд оролцогчдын материалыг дуудлага худалдаа явуулахаас 24 цагийн өмнө хааж, дуудлага худалдаа эхлэх цаг болмогц оролцогчдод бичиг баримтын үнэн зөв эсэх болон дэнчин төлсөн байдлыг шалгаж, ирсэн хүсэлтүүдийг оролцогч тус бүрээр нь ялган тавьж бүртгэнэ.

6.5. Бүртгэлийн материалаас ташаа мэдээлэл илэрсэн, эсхүл тухайн дуудлага худалдаанд оролцох хүсэлт биш тохиолдолд холбогдох этгээдийг дуудлага худалдаанд оролцуулахгүй. Энэ талаар тэмдэглэлд бүртгэнэ.

6.6. Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд нууцалж, бусдад энэ талаар мэдээлэл өгөхийг хориглоно.

Долоо. Дуудлага худалдаа явуулах

7.1. Аймгийн Засаг дарга дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг байгуулж, дуудлага худалдааг ажлын хэсэг зохион байгуулна.

7.2. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг нь дарга, дуудлага худалдааны хөтлөгч (зарлагч), тэмдэглэл хөтлөгч гэсэн үүрэг бүхий энэ удирдамжийн 1.3-т заасан бүрэлдэхүүнтэй байна.

7.3. Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг тухайн дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

7.4. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга дор дурдсан эрх, үүрэгтэй.

7.4.1. Дуудлага худалдаа явуулах ажлыг бүрэн хариуцах;

7.4.2. Дуудлага худалдаа явуулахад зөвлөх ажилтныг сонгон ажиллуулах;

7.4.3. Дуудлага худалдааны явцын тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгийг үнэн зөв, бүрэн хөтлөгдсөн эсэхийг хянаж баталгаажуулан, дуудлага худалдаанд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсэг зурна

7.5. Дуудлага худалдааны хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.5.1. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, хувийн дугаар олгох;

7.5.2. Дуудлага худалдааг товлосон хугацаанд нь эхлүүлэх;

7.5.3. Үнэ хаялцуулах дэгийн дарааллын талаар болон өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлаж танилцуулах;

7.5.4. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх.

7.6. Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй

7.6.1. Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх;

7.6.2. Дуудлага худалдааг товлосон хугацаанд оролцогчдыг цахим хаягт оролцохыг утсаар холбогдож урих, оролцогч 2 дахь удаагаа урихад орж ирээгүй тохиолдолд түүнийг дуудлага худалдаанд оролцохоос татгалзсанд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусгана;

7.6.3. Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга оролцогчдод тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа явуулах захирамж, түүнтэй адилтгах шийдвэрийг уншиж сонсоно;

7.6.4. Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг оролцогчдын материалыг шалгасны дараа энэ удирдамжийн 7.5.1-д заасан дугаарыг хуваарилж олгоно;

7.6.5. Хөтлөгч оролцогчдод дуудлага худалдааны журам болон үнэ хаялцуулах дэг, анхааруулах бусад зүйлийг танилцуулна;

7.6.6.Хөтлөгч дуудлага худалдаанд явуулах цахим зохион байгуулалтыг танилцуулж, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлан, дуудлага худалдаа эхлүүлнэ

7.6.7.Өсгөн хэлэх үнийн хэмжээ Засгийн газрын тогтоолоор баталсан 2023 оны босго үнийн /доод хязгаар нь босго үнийн 10 %-иас доошгүй дээд хязгаар нь 50%-иас дээшгүй байна.

7.6.8.Оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тухайн үнийн саналыг 3 удаа давтаж хэлнэ;

7.6.9.Бусад оролцогчид энэ удирдамжийн 7.6.7-д зааснаас дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч “буулаа” гэж хэлээд “нэг”, “хоёр”, “гурав” гэж тоолсны дараа дохио өгч ялагчийг зарлаж, дуудлага худалдаа хаасныг мэдэгдэнэ;

7.6.10.Дуудлага худалдаанд оролцогчид дуудлага худалдааны тэмдэглэлд гарын үсэг зурна.

7.6.11.Цахим дуудлага худалдааг товлосон өдрийн цаг, минут, секундэд эхлүүлж, мөн өдрийн цаг, минут, секундэд зогсооно;

7.7.1.Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлж, Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах үүрэгтэй

7.7.2.Цахим худалдааг заасан хугацаанд зогсоосноор оролцогчдоос ирүүлсэн үнийн

санал тус бүрийн хугацааг цаг, минут, секундээр бүртгэн тэмдэглэлд тусгана.

7.7.3.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг ажлын 5 өдөрт багтаан буцаан шилжүүлэх бөгөөд шилжүүлэх данс тодорхойгүй тохиолдолд цахим бүртгэл дэх утас, хаягаар оролцогчтой холбогдож шилжүүлнэ;

7.8.Дуудлага худалдаа явуулахтай холбогдсон энэ удирдамжаар зохицуулаагүй харилцааг Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Амьтны тухай хуулийн 29,¹ заасны дагуу зохицуулна.

7.9. Дуудлага худалдаанд зөвхөн 1 оролцогч оролцсон эсхүл дуудлага худалдааны анхны үнээс дээш үнийн санал гараагүй тохиолдолд дуудлага худалдааг явагдаагүй гэж үзэн дахин тов зарлана.

Найм. Дуудлага худалдааг дахин явуулах

8.1.Дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

8.1.1.Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан тусгай зориулалтын агнуурын хураамж, агнуурын нөөц ашигласны төлбөр, дуудлага худалдааны төлбөр, гэрчилгээний үнийг энэ удирдамжийн 7.7.1-т заасан хугацаанд бүрэн төлөөгүй, эсхүл төлөхийг зөвшөөрөөгүй тохиолдолд;

8.1.2.Дуудлага худалдаа явагдаагүй болон явуулах нөхцөл бүрдээгүй;

8.1.3.Дуудлага худалдааг хууль зөрчин явуулсныг шүүхийн шийдвэрээр тогтоосон;

8.1.4.Хуульд заасан бусад тохиолдолд.

8.2.Дуудлага худалдааг дахин явуулах шийдвэрийг аймгийн Засаг дарга гаргах бөгөөд дуудлага худалдааны зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс хуанлийн 5-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

8.3.Дуудлага худалдааг дахин явуулахдаа энэ удирдамжийг мөрдөнө.

8.4.Энэхүү удирдамжийн 8.1-д заасан дуудлага худалдаанд 1 оролцогч оролцох хүсэлт гаргасан тохиолдолд дуудлага худалдааны анхны босго үнэ дээр өсгөн хэлэх үнийг доод хэмжээг нэмж, дуудлага худалдаагаар худалдан авах үнийг

тогтоох бөгөөд тухайн оролцогч зөвшөөрсөн тохиолдолд түүнийг дуудлага худалдааны ялагч гэж үзнэ.

Ес. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах

9.1.Дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулна.

9.2.Дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор энэ удирдамжийн 9.1-т заасан дуудлага худалдааны гэрээнд туссан үнийг бүрэн төлнө.

9.3.Дуудлага худалдааны ялагч энэ журмын 9.2-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнэ, агнуурын нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төлснөөр аймгийн Засаг дарга энэ удирдамжийн 9.1 дахь гэрээ, өргөдлийг үндэслэн тусгай зориулалтын агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг олгоно.

Арав. Дуудлага худалдааны үнэ, дэнчин

10.1.Дуудлага худалдааны анхны үнийг Засгийн газрын тогтоолоор баталсан үнийг баримтлана.

10.2.Дэнчинг Байгаль орчны газрын нэмэлт орлогын 100180013401 дансанд байршуулна.

10.3.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

Арван нэг. Дуудлага худалдааны орлогыг тайлагнах, зарцуулах

11.1.Дуудлага худалдааны орлогын 50 хувийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д заасан Байгаль орчин, уур амьсгалын санд шилжүүлнэ.

11.2.Дуудлага худалдааны нийт орлогын 50 хувийг аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

Арван хоёр. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг

12.1.Албан бичгээр ирүүлсэн хүсэлт

12.2.Менежмент хариуцагч, орон нутагтай байгуулсан гэрээний хуулбар

12.3.Дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлсөн баримт

12.4.Агнуурын нөөц ашигласны төлбөрийг төлсөн баримт

12.5.Агнуурын нөөц ашигласны хураамж төлсөн баримт

12.6.Анчны паспортын хуулбар гэсэн бичиг баримтуудыг хүлээн авч ан агнах зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан олгоно.

Арван гурав. Маргаан шийдвэрлэх

12.1.Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг шийдвэрлэнэ.

12.2.Аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаатай холбогдсон гомдлыг ажлын 3 өдөрт багтаан тухайн шатны Засаг дарга болон шүүхэд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН.....
ЗАХИРАМЖИЙН АЖЛЫН ХЭСЭГ

ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
/байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, түүний төлөөлөл бөглөх/

1. ХҮСЭЛТ ГАРГАГЧ АЖ АХУЙ, НЭГЖ, ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Оноосон нэр	
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	
3. Регистрийн дугаар	
4. Холбоо барих утас	
5. Хаяг	аймаг /нийслэл/.....сум (дүүрэг)баг (хороо) гудамж (хороолол) байр (хашаа, хаалга)- ны дугаар.....

2. ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

1. Иргэний харъяалал	
2. Ургийн овог	
3. Эцэг эхийн нэр	
4. Регистрийн дугаар	
5. Холбоо барих утас	
6. Цахим шуудангийн хаяг	
7. Оршин суух хаяг	аймаг /нийслэл/.....сум (дүүрэг)баг (хороо) гудамж (хороолол) байр (хашаа, хаалга)- ны дугаар.....
8. Холбоо барих бусад хүний нэр, утасны дугаар	

3. ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ДЭНЧИНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1. Төлсөн дэнчингийн хэмжээ (төг).....	Нийт төлсөн төлбөрийн хэмжээ(төг) тоогоорүсгээр	
2. Дуудлага худалдаанд оролцох амьтны зүйлийн нэр, тоо хэмжээ	Амьтны зүйлийн нэр, тоо, хэмжээ	
	Амьтны зүйлийн нэр, тоо хэмжээ	
	Амьтны зүйлийн нэр, тоо хэмжээ	
	Амьтны зүйлийн нэр, тоо хэмжээ	
3. Дэнчин төлсөн огноо		

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН: ЭЦЭГ ЭХИЙН НЭР, НЭРИЙГ БҮТНЭЭР БИЧНЭ.